



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ШИНЭ АНАГААХ УХААН ИХ СУРГУУЛЬ
Хөтөлбөрийн нэр: АНАГААХ УХААН

Индекс: 091201 Бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Лагшмаа

Гишүүд: П.Пунсалдулам
Л.Мөнхтулга

2022.12.13

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	3
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	4
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	6
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	6
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	15
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	18
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	21
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	25
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	31
I. Багш нарын нэрс	31
II. Оюутнуудын нэрс	32
III. Ажил олгогчдын нэрс	33
IV. Төгсөгчдийн нэрс	34
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	35

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	Шинэ Анагаах Ухаан Их Сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	Анагаах ухаан	
Индекс	091201 бакалавр	
Шинжээчид	<p>Ахлагч:</p> <p>1. Б.Лагшмаа. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн Монгол Анагаах ухааны олон улсын сургуулийн багш, Анагаах ухааны доктор, дэд профессор</p> <p>Гишүүд:</p> <p>2. П.Пунсалдулам. Ач Анагаах Ухааны Их сургуулийн Эмгэг судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор</p> <p>3. Л.Мөнхтулга. “Universal Med” эмнэлгийн захирал, Анагаах ухааны доктор, профессор</p>	
Зохицуулагч	Б.Оюунчимэг Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу/
	2022.11.02	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.
	2022.11.02 №48/2022	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022.11.14	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.11.17,18	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.11.30	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022.12.02	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2022.12.06	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн баг сургуульд ажиллахаас хоёр долоо хоногийн өмнө хүлээн авч, уншиж танилцсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан нь өмнөх үг, үндсэн 7 шалгуур, шаардлага гэсэн бүтэцтэй бичигдсэн байна, шалгуур бүрд чанарын менежментийн PDCA циклийн дагуу дүгнэлт, SWOT шинжилгээ хийгдсэн. Шинжээчийн баг тайлангийн бүтэц, бичилтийн агуулга нь магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шаардлага, үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, статистик судалгааны дүгнэлт, өгөгдлийн нотлох баримтууд зэргийг нягтлан үзэж, урьдчилсан байдлаар тайланд тодорхойгүй байгаа хэсгүүдийг тодорхойлж, тодруулах асуултуудыг гаргаж бэлтгэсэн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Шинэ Анагаах Ухаан их сургуулийн Анагаах ухааны сургууль нь 2015 оны 01-р сарын 05-ны өдрийн захирлын Б/03 тоот тушаалаар сургуулийн үйл ажиллагаа өргөжин тэлж, шинээр зарим мэргэжлийн бакалаврын анги нээхтэй холбоотойгоор 2016 оны 07-р сарын 01-ний өдрөөс Ерөнхий анагаах ухааны салбар, 2017 оны 07-р сарын 02-ны өдрийн Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн ректорын тушаалаар Анагаах ухааны сургууль болсон. Шинэ АУИС-ийн Анагаах ухаан бакалаврын хөтөлбөрийг зургаа дахь жилдээ хэрэгжүүлж 2021-2022 оны хичээлийн жилд анхны төгсөлтөөр 49 оюутан их эмч мэргэжлээр төгссөн. Анагаах ухаан бакалаврын хөтөлбөрийг хүний их эмчид тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэн гаргахад анхаарч өнөөгийн эрүүл мэндийн салбарын эрэлт хэрэгцээ, төр, захиргааны байгууллагуудаас гаргасан хууль дүрэм, эрх зүйтэй уялдуулан шинэчлэн боловсруулж ирсэн байна. Сургалтын төлөвлөгөө NCM (newly coded medicine) онолыг үндэслэн боловсруулагдсан бөгөөд сургалтын явцад оюутан эмнэлзүйн шинжлэх ухааныг физиологийн нарийн мэдлэгээр баяжуулж NCM онолын үндэслэлтэй судалдаг байна. Хөтөлбөрийн онцлог нь хувь хүнд суурилсан хандлагаар өвчин эмгэг, эрүүл ахуй, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эм зүй, хоол судлал зэрэг ухааныг хослуулан судалж байна. Хувь хүнд тохирсон эм болон хоолны шингээлтийн онцлог, өвчин эмгэг үүсэхэд эсийн түвшинд гарах өөрчлөлтийг анхааран зааж, шинэ онолоор баяжуулсан мэдлэгтэй эмч нарыг бэлдэж байна.

Зорилго:

Танин мэдэхүйн бүтэн тайлал дээр суурилсан уламжлалт ба орчин үеийн анагаах ухаан, шинэ NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологиор дэлхийн түвшингийн эмч, судлаач бэлдэнэ.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Танин мэдэхүйн бүтэн тайлал дээр суурилсан уламжлалт ба орчин үеийн анагаах ухаан, шинэ NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологиор дэлхийн түвшингийн эмч, эм зүйч, эмнэлгийн мэргэжилтэн, судлаач бэлдэнэ.

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

Сургуулийн эрхэм зорилгын дагууд “Сургалтын өмнө нь баримтлагдаж ирсэн суурь цөм хөтөлбөрүүдийн агуулга, 21-р зууны шинжлэх ухааны ололт амжилт, англи хэл дээрх ном, сурах бичиг - Олон улсын хөтөлбөрт суурилсан агуулга (Соёмбо хөтөлбөр), NCM шинэ мэдлэгт суурилсан хөтөлбөрийн агуулга” гэсэн өөр хоорондоо нарийн холбоо бүхий гурвалсан хандлага гэсэн сургалтын технологиор бакалаврын боловсрол эзэмшсэн хүний их эмч нь зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэргээн засах, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн тусламж үйлчилгээг МУ-ын стандартын дагууд гардан зохион байгуулахдаа амьд эсийн доторх мембран-редоксопотенциалын 3 төлөвт шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онол дээр суурилан оношилгоо, эмчилгээний өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж байдаг төгсөгч их эмчийн цогц чадамжтай эрүүл мэндийн бүхий л шатны байгууллагад ажиллах чадвар бүхий төгсөгч ирээдүйн эмчид төлөвшүүлэхэд оршино.

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

- Ерөнхий суурь хичээл 58 багц цаг (21%) байна. Үүнээс 46 багц цагийн хичээлийг заавал судлах байдлаар, үлдсэн 12 багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судалж байна.
- Мэргэжлийн суурь хичээл нийт 64 багц цаг (23.2%) байна. Үүнээс 58 багц цагийн хичээлийг заавал судлах байдлаар, үлдсэн 1 багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судалж байна. Үйлдвэрлэлийн дадлага 5 багц цаг байна.
- Мэргэшүүлэх хичээл 154 багц цаг (55.8%) байна. Үүнээс 153 багц цагийг заавал судлах байдлаар, 1 багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална. Үйлдвэрлэлийн дадлага 24 багц цаг байна.

Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт

Ерөнхий мэргэжлийн анагаах ухааны бакалаврын сургалтын хөтөлбөрийн хичээлийн онол, дадлага, үйлдвэрлэлийн дадлагын харьцаа сургалтын хэлбэр тус бүрээр тооцоход:

- Ерөнхий суурь хичээлийн 488 цаг онол, 880 цаг дадлагын хичээл орж байна.

- Мэргэжлийн суурь хичээл 512 цаг онол, 864 цагийн дадлага, үйлдвэрлэлийн дадлага 200 цаг орж байна.
- Мэргэшүүлэх хичээл 1128 цаг онол, 1904 цагийн дадлага, үйлдвэрлэлийн дадлага 3992 цаг орж байна.

Хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг багш нарын эрдмийн зэрэг

Багшийн эрдмийн зэрэг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Магистр	69%	70.37%	69.1%	69%	68.50%
Доктор	31%	29.62%	29.80%	31%	31.5%

Хөтөлбөрийн нэг багшид ноогдох оюутны тоо

Багш, оюутны тоо	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Багшийн тоо	52	54	54	74	73
Оюутны тоо	222	256	297	403	342
Нэг багшид ноогдох оюутны тоо	4.26	4.74	5.5	5.44	4.68

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хөтөлбөр нь байгаль, хүмүүнлэгийн ухааны хичээлүүдээс бүрдсэн ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон эрүүл эмгэгийн үеийн бие махбодын бүтэц, үйлийг судлах анагаахын ерөнхий суурь хичээлүүд, эрхтэн тогтолцоо бүрийн эмгэг, тэдгээрийн эмгэг жам, шалтгаан эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний талаар судлан үзэх мэргэшүүлэх хичээлүүдээс бүрдсэн байна. Сургалтын хөтөлбөрүүдийг төрийн захиргааны төв байгууллагуудаас гаргасан хууль эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан тэдгээрт зохицуулан шинэчилж, өөрчилж ирсэн байна. Мөн салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан дүн шинжилгээ, бенчмарк хийж өөрийн хөтөлбөрийг дүйцүүлэн дүгнэлт хийж хэрэгжүүлж байна. Шинэ анагаах ухаан их сургууль нь Боловсрол шинжлэх ухааны сайдын А/78, А/174, А/370, А285 тоот тушаалуудын дагуу хүний их эмч мэргэжлээр бакалаврын сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан сургалтын үйл ажиллагаа эрхлэн ажиллаж байна. Шинэ анагаах ухаан их сургуулийн Анагаах ухааны сургууль нь үйл ажиллагаа өргөжин тэлж, шинээр зарим мэргэжлийн бакалаврын анги нээхтэй холбоотойгоор 2016 оноос Ерөнхий анагаах ухааны салбар, 2017 оноос Анагаах ухааны сургууль болж байгуулагдсан. Шинэ анагаах ухаан их сургууль нь “Анагаах ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүний их эмч нарын ажлын байрны эрэлт хэрэгцээ, шаардлагын судалгаа явуулж, “Анагаах ухаан” хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг судалж, БШУЯ, Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд CDIO, PDCA зарчмыг баримтлан үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтанд оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Онцлог зүйл:

- Анагаах ухаан бакалаврын сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөлтийг зохион байгуулахад Шинэ АУИС-ийн хөтөлбөрийн хороо, Захирлын зөвлөл, Ректорын их семинар болон NCM-Эрдмийн сургууль, АУС-ийн тэнхмийн нэгжүүд хамтран ажиллаж сургуулийг хөгжүүлэх ойрын ба хэтийн бодлого чиглэлийг тодорхойлж, 2050 он хүртэлх алсын харааг тодорхойлсон байна.
- Нийгмийн эрэлт хэрэгцээ, салбарын хөгжил, хүний нөөцийн бодлогод тулгуурлаж боловсон хүчин бэлтгэж байгаа. Шинэ мэдлэгээр, шинэ онолоор баяжуулагдсан, гурвалсан хандлага бүхий амьд эсийн доторх мембран-редоксопотенциалын 3 төлөвт шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онолд суурилсан сургалтын арга зүй, технологит суралцаж бакалаврын боловсрол эзэмшсэн хүний их эмчийн цогц чадамжтай эрүүл мэндийн бүхий л шатны байгууллагад ажиллах чадвар бүхий төгсөгч ирээдүйн эмчийг бэлтгэх зорилготой ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Бакалаврын сургалтад судлах кредитын тоо их байна. БШУСайдын А/348 тушаалаар нэг семестрт орох хичээлийн кредит заасан тул мөрдөх
- Хөдөлмөрийн зах зээлд шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг судалж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж ажиллах, хөтөлбөрийн зорилго болон төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг үүнд тохируулан тодорхойлох

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан кредитын тоог зохистой болгох
- Ажлын байрны тодорхойлолт болон хөтөлбөрийн цогц чадамжийн хооронд уялдаа холбоог сайжруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Төгсөгчид нь хүний их эмчийн мэргэжил эзэмшиж байгаа бөгөөд шинэ NCM онолын мэдлэгт суурилсан хувь хүнд чиглэсэн оношилгоо эмчилгээний арга барил, хоол шим тэжээлийн онолын мэдлэг, УАУ-ны онолоор баяжуулагдсан мэдлэг эзэмшдэг.

Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн төгсөгч их эмчийн цогц чадамжийн загварыг Монгол улсын MNS 5323-124:2012 стандартын дагуу боловсруулж төгсөгчийн эзэмших танин мэдэхүйн чадамж, мэдлэг, чадвар, иргэний төлөвшилт, ёс суртахууны чадамж, хандлага гэсэн дэд бүлгүүдээр тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн төгсөлтийн дараах сургалтад хамруулах, нарийн мэргэжил эзэмших боломжид анхаарах, бусад ижил төст сургуулийн төгсөгчидтэй өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийг төгсөлтийн дараах сургалтад хамруулж, нарийн мэргэжил эзэмших боломжийг нэмэгдүүлэх.
- Бусад сургуулийн ижил хөтөлбөрийн төгсөгчидтэй өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн зорилго, үнэт зүйлс, бодлого, төлөвлөлт нь мэргэжлийн стандарт, мэргэжилтний загвар, ажлын байрны тодорхойлолтын дагуу боловсруулагдсан байна. Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоход сургуулийн захирал, захиргаа багш, оюутантай долоо хоног бүр уулзалт хийж, тэдний саналыг тусгадаг нь ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн ярилцлагаар нотлогдож байна. Хөтөлбөрийн төлөвлөлтийг хийхдээ Шинэ АУИС нь боловсролын хууль эрх зүйн баримтуудыг мөрдлөг болгон тэдгээрийг мэргэжлийн стандартад уялдуулан хурлын тэмдэглэл, санал асуулга, дүгнэлтээр нотолгоожуулан мэдээллүүдийг эмх цэгцтэйгээр бүрдүүлсэн байна. Сургалтын хөтөлбөр 2016 онд анх

боловсруулагдан, 2021 онд БСШУС-ын А/174 тоот тушаалын дагуу шинэчлэгдэн батлагдсан байна. 2022-2023 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд 2022 оны БШУСайдын А/348 тоот тушаалын дагуу шинэчлэл хийх ажил тусгагдсан байна.

Онцлог зүйл:

- Сургалтын төлөвлөгөө НСМ онолын хүрээнд гаргаж боловсруулагдаж сурган заах арга зүйг шинэ онолтой холбож гаргасан нь “шинэлэг, сурах чадамжийн сайжруулдаг, цаг хэмнэдэг” гэж тэмдэглэсэн байна.
- Хөтөлбөрт тусгагдсан эмнэлзүйн хичээл орох сургалтын бааз эмнэлгүүдтэй гэрээ хийж сургалтад ашиглаж байна.
- Хөтөлбөр сайжруулах зорилгоор удирдлагын баг 7 хоног бүр оюутан, багш нартай урт богино хугацааны ярилцлага зохион байгуулж байна. Мөн тэмдэглэл хөтөлбөр сайжруулах зорилгоор багш, оюутан, төгсөгчид, ажил олгогчдыг оролцуулан уулзалт зохион байгуулж саналыг тусган ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөнд 6 жилийн хугацаанд 276 кредит судалдаг. Өөрөөр хэлбэл нэг семестрт 19-29, нэг жилд 44-49 кредитын хичээл орж байна. Оюутны ачаалал хэт их байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, ирээдүйн чиг хандлагад сурган заах аргазүй, үнэлгээг боловсронгуй болгох асуудлыг тусгаж, багш хөгжлийн төв хариуцаж ажилладаг боловч үүнд багш бүр бүрэн хамрагдаагүй байна.
- Сургалтыг явуулах хэлбэрүүдийг чадамжид суурилсан, харилцаанд суурилсан хэлбэрээр зохион байгуулдаг гэж тайлагнасан хэдий ч, хэрхэн яаж, ямар арга зүйгээр явуулах талаар хөтөлбөрт тодорхой оновчтой тусгагдаагүй, НСМ-сургалтын шинэлэг санааг хэрэгжүүлэх хөтөлбөрөөр төгсөгч нь ямар цогц чадамж, уян хатан чадварыг (soft skills) эзэмшсэн байхыг тодорхойлоогүй

Зөвлөмж:

- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрт хичээл тус бүрээр хүрэх үр дүн үүнд зохих сурган заах арга зүй, үнэлгээний аргуудыг оруулах;
- БШУСайдын А/174 тоот тушаалд нийцүүлэн сургалтын төлөвлөгөөний багц цагийн харьцааг шинэчилж, суралцагчдын ачааллыг тэнцвэржүүлэх;

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна гэсэн заалтын дагуу зохион байгуулагдаж байна. Үр дүнд суурилсан “Сургалтын өмнө нь баримтлагдаж ирсэн суурь цөм хөтөлбөрүүдийн агуулга, 21-р зууны шинжлэх ухааны ололт амжилт, англи хэл дээрх ном, сурах бичиг - Олон улсын хөтөлбөрт суурилсан агуулга (Соёмбо хөтөлбөр), NCM шинэ мэдлэгт суурилсан хөтөлбөрийн агуулга” гэсэн өөр хоорондоо нарийн холбоо бүхий гурвалсан хандлага бүхий дээд боловсрол олгох хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахуйц “Танин мэдэхүйн бүтэн тайлал дээр суурилсан уламжлалт ба орчин үеийн анагаах ухаан, NCM анагаах ухааны гурвалсан тогтолцоот сургалтын технологиор дэлхийн түвшингийн эмч, судлаач бэлдэнэ” гэсэн сургуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэх гурвалсан хандлага бүхий амьд эсийн доторх мембран-редоксопотенциалын 3 төлөвт шугам хамааралт протон, электроны урсгалын 9 дамжлагат битүү хэлхээний онолд суурилсан сургалтын арга зүй, технологит суралцаж бакалаврын боловсрол эзэмшсэн хүний их эмчийн цогц чадамжтай эрүүл мэндийн бүхий л шатны байгууллагад ажиллах чадвар бүхий төгсөгч ирээдүйн эмчид бэлтгэхэд чиглэгдсэн байна.

Онцлог зүйл:

- Сургалтад нэвтрүүлсэн NCM мэдлэгт суурилсан ерөнхий мэргэжлийн анагаах ухааны сургалтын хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан PDSA аргачлалаар боловсруулагдсан.

- Сургуулийн захирал хөтөлбөрийн төлөвлөлт, шинэчлэлтэд байнга анхаарал хандуулж долоо хоног бүр багш нартай уулзалт биечлэн зохион байгуулж сургалтын явцад үнэлгээ хийж, багш нарын саналыг үйл ажиллагаанд тусгаж байна.
- Анагаах ухааны сургалтын нэг гол хэсэг нь өвчтөнд тавигдсан оношийн дагууд хоолыг зөв хэрэглэх, эмийг бага тунгаар өндөр идэвхи гарган хэрэглэх явдал бөгөөд энэ хоёр чиглэлийг “нэг тогтолцоонд” оруулан ажиллаж байна.
- НСМ онолд үндэслэн амьд эсийн тодорхойлолтыг шинээр гаргаж, бүх хичээлийн тодорхойлолтын өөрчлөн сургалтын агуулгыг шинэчилсэн.
- Сургалт шугаман хэлбэрээр явагддаг бөгөөд сургалтын төлөвлөгөөнд заавал судлах хичээл, сонгон суралцах хичээл, факультатив хичээлүүдийг тусгасан.
- Хичээлийн онол, практикийн харьцааг 1:2 гэж сургалтыг зохион байгуулдаг бөгөөд хичээлийн лекц, дадлага, бие даалтын цаг нь хичээлийн онцлогоос хамаардаг.

Анхаарах асуудал:

- Хичээлийн давхардал харагдаж байна, учир нь НСМ онолын талаар мэдлэг хичээл, мэргэжил тус бүрт орсон байна.
- Хичээл сонгох боломж хязгаарлагдмал, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан тоотой хичээлүүд сонгоноор орж байна.

Зөвлөмж:

- Сонгон суралцах, бие даан суралцах боломжийг сайжруулах, насанд хүрэгсдийн сурган заах арга зүйг нэвтрүүлэх
- Сургалтын агуулга, цогц чадамжийн хоорондох хамаарлыг сайжруулан шинэчлэх
- Оюутны бие даалтын сэдэв, гүйцэтгэх даалгавар, үнэлгээг тодорхой болгож хөтөлбөр тус бүрт тусгах
- Хөтөлбөрийн модыг цогц чадамжид нийцүүлэн заах арга зүй, үнэлгээний аргатай уялдуулан боловсруулах.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Онол, практик, эмнэлзүйн сургалтын хосолсон хэлбэрээр сургалтыг зохион байгуулах шаардлагын дагуу Шинэ АУИС нь Улаанбаатар хотын томоохон клиник, төрөлжсөн эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны болон түншлэлийн гэрээ байгуулах замаар эмнэлзүйн бааз эмнэлгийн тоог нэмэгдүүлсэн нь сургалтын чанар дээшлүүлэх, оюутны эмнэлзүйн сэтгэлгээг хөгжүүлэх, эмнэлгийн орчин оруулах чухал ач холбогдолтой байна.

- ШАУИС-ийн Анагаах ухааны сургалтын 2012, 5323:124 стандартын дагуу хэчээл бүрийн хэрэгжилтийг “Соёмбо мэдлэг – NCM мэдлэгээр баяжуулсан англи хэл дээр суурилсан гурвалсан хөтөлбөр”-ийг чанарын өндөр түвшинд бэлтгэсэн мэдээллийг өдөр бүр багш оюутан бүр рүү илгээж хангадаг.
- Багш нарын өөрийн эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжтай байдал, багш нарын заах арагзүйн судалгаа, сурган заах арга ашигладаг байдал, сургалтын олон талт хэлбэрүүдийг ашигладаг байдал үнэлж судалгаа явуулдаг байна.

Зөвлөмж:

- Суралцагч төвтэй сургалт гэдгийг сургалтын хөтөлбөрт тодорхой тусгах, хичээлийн төрөл бүрийн хэлбэрүүдийг зохистой оруулах
- Дэвшилтэт технологи ашиглалтыг сайжруулах
- Хөтөлбөрийн модыг цогц чадамжид нийцүүлэн хүрэх үр дүн, заах арга зүй, үнэлгээний аргуудтай уялдуулан боловсруулах
- NCM-сургалтын шинэлэг санааг анагаах ухааны сургалтад хэрхэн нэвтрүүлэх сургалтын технологийн стандарт, арга зүйг загварчилж батлан, мөрдөж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

ШАУИС-ийн Анагаах ухаан хөтөлбөрт мөрдөж буй оюутны мэдлэг, чадварын үнэлэх системд дүгнэлт хийж оновчтой байж чаддаг эсэх талаар судалгаа хийсэн байна. Багш нар хичээлдээ дараах үнэлгээний аргуудыг ашиглаж байна. Үүнд: аман хэлбэрийн ярилцлага, дасгал ажил, аман хэлбэрийн илтгэл, хувилбарт хариулттай

асуулт, мэргэжлийн хэлэлцүүлэг, эмнэлзүйн кейс судалгаа орж байна. Харин симуляци, дүрд тоглох, портфолио аргуудын ашиглалт дундаас бага байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн эзэмшиж байгаа мэдлэг, чадвар, хандлагыг Блүүмийн таксономи, Рубрикийн зарчмаар харуулж, цогц чадамж бүрт үнэлгээний аргуудыг оновчтой сонгох.

Зөвлөмж:

- Оюутны үнэлгээний аргуудыг орчин үеийн боловсрол судлалын чиг хандлагын дагуу илүү боловсронгуй болгох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын зориулалтаар ашиглаж байгаа нийт талбайн хэмжээ- 3839.8 м.кв. Эдлэн газрын хэмжээ-14 га, нэг оюутанд ноогдох ашигтай талбайн хэмжээ- 3.66м.кв, кабинетийн нэг суудалд ноогдох ашигтай талбай - 4.3м.кв, лабораторийн нэг суудалд ноогдох ашигтай талбай - 2.9м.кв, хоолны газрын нэг суудалд ноогдох талбай - 1м.кв Мэргэжлийн хичээлийн лаборатори 11 байгуулсан бөгөөд 21 эмнэлэгтэй гэрээ байгуулан сургалт болон ур чадвар эзэмшүүлэх дадлага хийх чиглэлээр хамтран ажилладаг байна.

Онцлог зүйл:

Оюуны өмчийн патент бүхий NCM анагаах ухаан, NCM эмнэлзүй, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны түгээмэл зүй тогтолд тулгуурлан англи хэл дээр суурилсан Соёмбо хөтөлбөрөөр E-контент 509 удаагийн цуврал хичээлийг бэлтгэн цахимд байршуулсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих

хүрээнд ургамал тарималжуулах биостанц, биохүрээлэн, эрдэм шинжилгээ-инновацийн төвийн лабораторийг 250 сая төгрөгөөр байгуулсан байна

Зөвлөмж:

- Лабораторийн орчныг сайжруулан стандартын дагуу зохион байгуулах, тоог нэмэгдүүлэх, оюутны хичээл хийх нөхцөлийг сайжруулах

Шаардлага:

- Сургалтад шаардлагатай эмнэлзүйн сургалт, судалгаа, ур чадварын төв болон лабораторийг зохих шаардлагад нийцүүлэн байгуулах

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн хөтөлбөрийн агуулгаас хамааран хэрэглэгдэхүүнийг багш хариуцах (БХ), сургуульд байгаа (СБ), оюутан хариуцах (ОХ) байдлаар урьдчилан төлөвлөдөг бөгөөд 89 хичээлийн хөтөлбөрт давхардсан тоогоор 32947 хэрэглэгдэхүүн тусгагдсан.

Анхаарах асуудал:

- Лабораторийн дадлагын хичээлд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, хэрэгсэл болон урвалж оношлуурын хүртээмжийг нэмэгдүүлэх буюу лабораторийн туршилтыг олон тооны оюутан нэгэн зэрэг гүйцэтгэх боломжтой болгох

Шаардлага:

- Лабораторийн аюулгүй ажиллагааны заавар байршуулах
- Техник ашиглалтын бүртгэл тогтмол хөтөлж хэвших
- Тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны заавар байршуулах

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Номын сан нь 138кв.м талбайтай. 85 хүний суудалтай чөлөөт уншлагын танхимтай. Номын сангийн үйлчилгээг өглөө 10.00 - 18.00 цагийн хооронд 2 номын санчийн орон тоотойгоор үйлчилж хүргэдэг.

Номын сан нь сургуулийн дотоод журмаар боловсруулж батлуулсан номын сангийн дүрэм, журамтай номын санд хөтлөгдөх номын нэгдсэн бүртгэл, нэг бүрчилсэн бүртгэл, өдөр тутмын бүртгэл болон өгөгдсөн ном зүйн лавлагаа, номын татгалзлын бүртгэл, сонин сэтгүүлийн бүртгэл зэргийг тогтмол хөтөлдөг.

Өдөрт дунджаар 70-80 хүн үйлчлүүлдэг, номын сангийн КОХА программ ашигладаг бөгөөд энэ программд 2022 оны эхний хагасын байдлаар 32038 (оюутанд зориулсан сурах бичиг, гарын авлагын тоо нийт 18907 байгаагаас ерөнхий эрдмийн ном сурах бичиг 2984) ном сурах бичиг бүртгэгдсэн.

Номын фондын бүтэц мэргэжлийн чиглэлээр

Он	Номын тоо						
	ДДА ангилал	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он/эхний хагас
Ерөнхий эрдэм	400-500	2774	2795	2869	2932	2979	2984
УАУ-ны чиглэл	615,8	6691	6812	6838	6939	6939	6940
ОУАУ-ны чиглэл	600-614	5894	6647	7206	7487	7916	8337
	616-618	4883	5103	5257	5407	5457	5572
Эм зүйн чиглэл	615-615.799	2545	2999	3060	3085	3113	3123
Бусад	000-300	1618	1687	1769	1817	1867	1877
	620-900	542	592	659	677	706	713
ЭШ-ний бүтээл, мэргэжлийн сэтгүүд, электрон ном		2231	2335	2440	2463	2477	2492
Дүн		27178	28970	30098	30817	31454	32083

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хичээлийн сурах бичиг, гарын авлага хомс байгаад анхаарах

Зөвлөмж:

- Мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага бичихэд мэргэжлийн холбоотой хамтран ажиллах
- Мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг зохиогчийн эрхийн дагуу цахим санг баяжуулах

Шаардлага:

- WIFI интернетийн үйлчилгээг тасалдалгүй хүргэх
- Оюутнуудын номын сангаар үйлчлүүлэх цагийн хуваарийг уртасгасан цагийн хуваарьт шилжүүлж, хүртээмжийг дээшлүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** Хэсэгчлэн хангасан**Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн хорооны хурлын протокол, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн богино, дунд, урт хугацааны мастер төлөвлөгөө, хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох талаарх бодлогын бичиг баримтууд, анагаахын салбар сургуульд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн эцсийн зорилгыг баталгаажуулсан баримт бичгүүд, сургуулийн бүтцэд хөтөлбөрийг боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэгт ажлын хуваарилалтыг тусгасан бичиг баримтууд

Онцлог зүйл:

- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн хичээлийн шинэ жил бүр эрхэм зорилгоо шинээр тодорхойлон ажиллаж байгаа

- Багш төвтэй, оролт, үйл явцад суурилсан сургалтын тогтолцооноос үр дүнд суурилсан (outcome-based) тогтолцоо руу шилжих үйл явцыг эхлүүлж, хөтөлбөрийн тасралтгүй хөгжүүлэлт хийхээр хичээн ажиллаж байна
- Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн богино, дунд, урт хугацааны мастер төлөвлөгөөг /2016-2024/ боловсруулж батлуулан, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байгаа
- Уламжлалт танхимын сургалтыг цахим сургалтын технологитой хослуулан суралцагчдын бие даан суралцах боломжийг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байна

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх алсын хараа, эрхэм зорилгоо нийтэд хүлээн зөвшөөрөгдөхүйц, ойлгомжтой, хүртээмжтэй, товч болгох
- NCM-сургалтын шинэлэг санааг анагаах ухааны сургалтад хэрхэн нэвтрүүлсэн сургалтын технологийн стандарт, арга зүйг тодорхой загварчилж гаргах
- Хөтөлбөр хэрэгжүүлэх богино /2016-2018/, дунд /2019-2021/, урт хугацааны мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дэлгэрэнгүй дүн шинжилгээ, тайланг хэлэлцэж, гарсан шийдвэр хангалтгүй байгааг анхаарах
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын санал зөвлөмжийг тусгасан байдлаа тодорхой болгох
- Суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох, хөтөлбөр боловсруулах хэсэгт сургууль, хөтөлбөр, хичээлийн түвшинд тус тус төсөөлсөн суралцахуй үр дүнг хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын саналыг хэрэгцээ шаардлагатай уялдуулан хэрхэн тусгаж тодорхойлдог болохыг тодруулах шаардлагатай
- Хөтөлбөрийг тасралтгүй сайжруулж, хөгжүүлэлт хийхдээ хөтөлбөрийн үнэлгээний үр дүнг хэрхэн ашиглаж, сайжруулалт хэрхэн хийснээ тодруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөг NCM-анагаахын салбар сургууль, түүний нэгжүүд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж, тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийн, хөтөлбөрийн тасралтгүй хөгжүүлэлт хийж ажиллах

- Хөтөлбөрийн шинэчлэлт, өөрчлөлт, хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлогоор хангаж ажиллах, хөтөлбөрийн хорооны бүтэц, үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхой зааж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Хамтын ажиллагааны гэрээ хэлцлүүд, ОХУ ба БНХАУ-ын их, дээд сургуулиуд руу туршлага судлахаар явсан багш нар, оюутан солилцоогоор явсан оюутнуудын тайлан, удирдах ажилтнууд ба багш нарын туршлага судалсан, мэргэжил дээшлүүлсэн тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Гадаад түншлэлийн хүрээнд ОХУ, БНХАУ-ын сургалт-судалгааны 11 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, үр бүтээлтэй ажиллаж байна
- Оюутан суралцагсдыг гадаад хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцооны хөтөлбөрт хамруулан ажиллаж байгаа
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хандив тусламж өгөх, сайн үйлсийн аянг өрнүүлж, уламжлал болгосон
- Төгсөгчдийн холбоо байгуулан, төгсөгчидтэйгээ эргэх холбоо тогтоох, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх зорилго тавин ажиллаж байгаа нь харагдаж байна

Анхаарах асуудал:

- Гадаад хамтын ажиллагааны гэрээнүүдийн хугацаа 2020 оноор дуусгавар болсныг анхаарах
- Анагаахын салбарт суралцдаг оюутнуудыг гадаадын оюутан солилцооны хөтөлбөрт хамруулсан эсэх нь тодорхойгүй
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй ажлаа боловсрол, хүмүүнлэг, сайн дурын ажил гэх мэтээр төрөлжүүлэн ажиллахад анхаарах

- Жил бүр төгсөгчдийг мөшгөх, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа хийж, үр дүнг тайлагнах, судалгааны үр дүнг хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусгаж ажиллахад анхаарах
- НМС-анагаахын хөтөлбөрөөр суралцаж төгссөн оюутнуудын төгсөлтийн дараах давтан сургалтад хамруулж, тоон мэдээллийг нарийвчлан гаргахад анхаарах

Зөвлөмж:

- Гадаад, дотоодын хамтын ажиллагааны гэрээнүүдийг шинэчлэх
- Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдийнхээ үр дүнг хөтөлбөрийн хөгжил шинэчлэлд ашиглах
- Багш, суралцагч нарыг тэтгэлэгт хөтөлбөрт ямар шалгуураар, хэрхэн сонгож авдагаа тодорхой болгох
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс нийгэмд үзүүлж буй үйлчилгээг өргөжүүлж, үйлчилгээг тогтмолжуулах
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулах
- Төгсөгчдийн холбооны хийж гүйцэтгэсэн ажлаа жил бүр тайлант ажилдаа тусгаж, эргэж төгсөгчиддөө мэдээлдэг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн ойрын болон хэтийн төлөвлөлт, сургуулийн болон салбар сургуулиуд, нэгжийн төсөв, санхүүгийн тайлан баланс, оюутан ба багш, ажилтанд үзүүлсэн урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтийн судалгаа тайлан, холбогдох эрх зүйн баримт бичгүүд, сургалтын төлбөрийн зарцуулалтад хийсэн тайлан мэдээ, анагаахын сургалтын хөтөлбөрт зарцуулсан зардлын тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Анагаахын хөтөлбөр хэрэгжүүлэгч сургалтын байгууллагын хувьд төрөөс болон бусад хувийн хэвшлийн байгууллагаас санхүүгийн дэмжлэг авч

ажилладаггүй, бусдаас санхүүгийн хараат бус, биеэ даасан, санхүүгийн чадамжтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг

- NCM анагаахын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд суурь судалгааны ажлыг санхүүжүүлэх чиглэлд ажиллаж буй нь давуу талтай байна
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд ургамал тарималжуулах биостанц, биохүрээлэн, эрдэм шинжилгээ-инновацийн төвийн лабораторийг 250 сая төгрөгөөр байгуулсан байна

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн агуулгын хүрээнд багш нарын бичиж хэвлүүлсэн ном, сурах бичгийн санхүүжилтэд зарцуулсан тайланг тоон дүнгээр, сурах бичиг тус бүрээр нь задалж гаргахад анхаарах
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог тодорхой болгох
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг болон түүний зарцуулалтын тайланг тодорхой болгох
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтыг тодорхой болгоход анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөвтэй болох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн баримт бичиг, хичээлийн хөтөлбөрийг хэлэлцэж баталгаажуулсан бичиг баримт, хичээлийн хөтөлбөрүүдийг шинэчилж ирсэн эрх зүйн баримт бичиг, төгсөгч ба ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх, хөтөлбөрийн өөрчлөлт, сайжруулалтыг ямар зураглалаар хийдгийг тодруулах

- Ажил олгогч байгууллагуудаас NCM-анагаахын хөтөлбөрийг дүүргэж төгссөн төгсөгчдийн ажлын байрны шаардлагад хэр нийцэж буй, хөтөлбөрт өгсөн ажил олгогчийн санал, үнэлгээг тодорхой тусгаагүй
- Суралцахуйн үр дүнгийн үнэлгээг хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт хийхэд хэрхэн ашигласан нь тодорхой бус
- Анагаахын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарын зүгээс багаар хамтарч хийсэн ажил хомс байгааг анхаарах

Шаардлага:

- Анагаах ухаан хөтөлбөрөөр төгсөгчийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ ямар байгаад дүн шинжилгээ хийж, үр дүнг өөрийн хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусгаж ажиллах
- Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг тогтмол явуулж, оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж оруулах
- Хөтөлбөрийн маркетинг хөгжүүлэлтэд багш нарын идэвх оролцоог нэмэгдүүлэх
- NCM шинэ мэдлэг олгох анагаахын хөтөлбөрийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар олон нийтэд таниулан сурталчилж, түүний үр ашиг, хамрах хүрээг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлсэн баримт нотолгоонууд, сургуулийн вебсайт дахь сургуулийн танилцуулга, гадаад дотоодын хэвлэлд нийтлүүлсэн өгүүлэл

Онцлог зүйл:

- NCM-анагаахын хөтөлбөрийг олон улсад таниулах зорилгоор профессор М.Амбага багшийн гадаад хэвлүүлсэн олон бүтээл байгаа

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын хөтөлбөрийг олон нийтэд таниулах чиглэлд хийсэн ажлын эзлэх хувь маш бага байгаад анхаарах
- Хөтөлбөрийн агуулгын хүрээнд бичигдсэн багш нарын ном сурах, бичиг хомс байгааг анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжүүд хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар олон нийтэд нээлттэй, үнэн зөв, ил тод мэдээлж, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагаа тодорхойлж ажиллах
- Сургуулийн вебсайтад хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй танилцуулга оруулж, цаг үеийн мэдээллийг тогтмол байршуулж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Элсэлтийн бодлого, дүрэм журам, элсэгчдэд зориулсан гарын авлага, шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага материал, элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, анагаахын салбарт элссэн элсэгчдийн тоон баримт бүхий судалгааны үр дүн, NCM-анагаахын салбар сургуульд элсэгчдийг холбогдох дүрэм, журам, тушаал шийдвэрийг үндэслэн элсэлтийн үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.

Онцлог зүйл:

“СОЁМБО-1-502” контент гаргаж, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн

Анхаарах асуудал:

- Дээд боловсролын тухай хуулийн 7 ба 12.1.6 дахь заалт, БСШУС-ын А/79 ба А/87 тоот тушаал, А/194 ба А/195 тоот тушаалыг үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа элсэгчид тусгайлсан ямар нэгэн шалгуур тавьдаггүй /тайлангийн хуудас 191/ гэж дурдсан боловч, тайлангийн 186 дахь хуудас дээр элсэгчид тодорхой шалгуур тавьдаг гэсэн нь анхаарал татаж байгааг анхаарах

- NCM-анагаах ухаанд суурилсан Анагаах ухааны хөтөлбөрийг шинэ элсэгчдэд тайлбарлаж ойлгуулах гарын авлагыг гаргах
- Суралцагчийг сонгох, элсүүлэх ажилд хэрхэн шинжлэх ухаанч аргаар ханддаг, элсэгчийг сонгон шалгаруулахдаа NCM-шинэ санаа, шинэ хандлагыг хэрхэн ашигладаг /тайлангийн хуудас 186/ шалгуур нь тодорхойгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн бичиг баримт, дүрэм журамдаа хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуураа тодорхой болгож оруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Оюутанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх албаны төлөвлөгөө, тайлан, сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийсэн материал, оюутан суралцагсдын дунд зохион байгуулсан сургалт, арга хэмжээний нэгдсэн тайлан мэдээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Шинээр элсэн орсон суралцагсдад чиглүүлэх сургалтыг тогтмол хийж, хэвшүүлсэн
- Шинээр элссэн оюутнуудад сурах арга барил, арга зүй эзэмшүүлэхэд сургуулийн Дотоод чанарын хяналтын баталгаажилтын алба нь хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нартай хамтарч ажилладаг
- NCM-анагаахын хөтөлбөрийг таниулах үүднээс 2016 оноос эхлэн “Хүн төрөлхтөний танин мэдэхүйн түүх” хичээлийг хөтөлбөрт шинээр тусгаж оруулсан

Анхаарах асуудал:

- “Оюутнуудын зохих ёсоор авч чаддаггүй мэдлэг”-ийн хувь хэмжээг сургалтан дээр багасгахад суралцагч руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг /тайлангийн хуудас 186/ гэсэн зөвлөн туслах үйлчилгээнийхээ талаар тодотгол өгөх, арга зүйг тодорхой болгох

- Оюутны бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх чиглэлд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар ямар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилладаг нь тодорхойгүй байна
- Удирдлага шинэ мэдлэг бүтээдэг, түүнийг сургуулийн нэгжүүдээр дамжуулан түгээж, шинэ мэдлэг олгох хоёрдугаар давалгааг эхлүүлдэг гэсэн /зураг 27/ зураглалд ямар судалгаанд суурилан дүгнэлт гаргаж ажилладаг, шинэ мэдлэгийг хэрхэн бүтээдэг арга зүйгээ тодорхой болгоход анхаарах
- “9 чадамжтай” багш нараар оюутанд “3 чадамж” эзэмшүүлэх чиг шугамаар СБЗА ажил үүргээ хэрхэн чиглүүлж ажилладаг нь тодорхой дурдагдаагүй байна

Зөвлөмж:

- Суралцагчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах
- Сургалтын үйлчилгээний чанарт үнэлгээ /суралцагч нараас сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авч хэвших/ хийн, тасралтгүй сайжруулалт хийж ажиллах
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Оюутны клуб, нийгэмлэгүүдийн танилцуулга, үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулсан арга хэмжээний тайлан мэдээ, оюутан суралцагсдын хийж гүйцэтгэсэн нийгэм рүү чиглэсэн сайн дурын ажлын үнэлгээ, тайлан, урамшуулал, цагийн ажил ба үндсэн ажилд зуучилсан оюутнуудын тоон мэдээлэл, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, урамшуулал ба тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан оюутан суралцагч нарын тоо

Онцлог зүйл:

- Оюутнуудыг төлөвшүүлэх чиглэлд оюутнуудын сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг сургуулийн зүгээс дэмжиж ажилладаг
- Оюутныг урамшуулах тэтгэлэгт хамруулах, хөнгөлөлт эдлүүлэх, нэрэмжит цалин олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх чиглэлд ажил зохион байгуулдаг

- Оюутнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог идэвхжүүлэх чиглэлд сургуулийн Оюутны хөгжлийн алба хичээн ажилладаг

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын клубуудын үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчинг хэрхэн бүрдүүлснээ тодорхой болгох
- Суралцагсдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажлын байраар хангаж ажилласан оюутны тоог салбараар нь ангилж, ажил эрхлэгч оюутантай хөдөлмөр эрхлэлтийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуулийн хэддүгээр заалтыг үндэслэж байгуулснаа тодорхой болгох
- Гадаадын гэрээт байгууллагуудад дадлага хийх, оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах оюутанг ямар журмаар сонгож шалгаруулдаг нь тодорхойгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Хөдөлмөр эрхлэгч оюутнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг нийгэмд таниулах үйл ажиллагааг дэмжиж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

Кредит дүйцүүлэх, шилжүүлэх журам, суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгааны үр дүн

Онцлог зүйл:

- Сургуулийн шилжилт, хөдөлгөөний тайлан мэдээнээс харахад, сүүлийн 5 жилийн байдлаар шилжиж ирсэн оюутны тоо /18/ нь шилжиж явсан оюутны тооноос /1/ их байгаа
- Суралцагсдын шилжилт хөдөлгөөнийг зохих дүрэм журмын дагуу шийдвэрлэдэг

Анхаарах асуудал:

- Томскийн Сибирийн Анагаах Ухааны их сургуультай 2018 онд байгуулсан гэрээний дагуу хэдэн оюутан шилжсэн талаар тодорхой дурдагдсан тоон баримт байхгүй байгааг анхаарах
- УАУ-ны ангиас Анагаах ухааны салбар сургууль руу хийгдсэн оюутны шилжилт хөдөлгөөний талаар тоон баримт дурдагдаагүй байгааг анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

Төгсөгчдийн мэдээллийн сан, төгсөгчдийн судалгаа, ярилцлага, төгсөлтийн баримт бичгийн загвар, төгсөлтийн дипломын хавсралтын загвар, төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Анхаарах асуудал:

- Төгсөгчдөд олгох диплом, дипломын хавсралт тус бүрийн нууцлалыг хэрхэн хангаж ажилладаг болохыг тодорхой тусгаагүй

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрийн хүний нөөцийг бүрдүүлсэн баримт бичиг, хэрэгжилтийн тайлан, багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүд, багш нарын нөөцийн судалгаа, багш нарын дэлгэрэнгүй судалгаа, хөдөлмөрийн гэрээ, шагнал урамшууллын судалгаа, удирдах ажилтан ба багш нарын судалгаа, багш нарт

зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой хийж гүйцэтгэсэн ажлын тайлангийн материал, докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь /сүүлийн 5 жилээр хийгдсэн судалгаа/, багш суралцагсдын тооны зохистой харьцааны судалгаа, багшийн цагийн ачаалал тооцох журам, цагийн ачаалал тооцсон судалгаа, багш нарт олгосон цалин, урамшууллын зардлын тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөтөлбөрийн хүний нөөцийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж, үндсэн багшийн эзлэх хувь 86.9% байгаа
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас сүүлийн 5 жилд 5 багш докторын зэрэг хамгаалсан байна

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийг дэмжих хууль, Дээд боловсролын багшийн хөгжлийн албаны хөгжлийн бодлоготой уялдуулан гаргасан дүрэм журам, багшийн хөгжлийн хөтөлбөр байхгүй
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын талаар хийгдсэн судалгаа байхгүй байгааг анхаарах
- Хүснэгт 70 дээр “Анагаах ухаан-D091201” хөтөлбөр хэрэгжүүлэгч багийн багш нараас 16 багш нь зөвлөх ба ахлах багш гэсэн гавьяа шагналтай байгааг анхаарах
- Хүснэгт 71 дээрх Анагаах ухааны хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын судалгаанаас харахад нэг багш 3-аас олон хичээл зааж байна
- Багш нарын ачаалал тогтоох, гүйцэтгэлийг тооцох журмын хүрээнд багш нарын жилд гүйцэтгэх ачааллыг сүүлийн 5 жилийн байдлаар ойлгомжтой, тоон үзүүлэлт, график дүрслэлээр харьцуулж харуулаагүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг зохих дүрэм журмын дагуу мөрдөж ажиллах
- Хөтөлбөрийн зорилгод нийцсэн хүний нөөцийн цогц бодлоготой болох /мэргэжлийн суурь хичээлүүдийг Уламжлалт анагаах ухаан төгссөн эмч нараар бус, Анагаахын хөтөлбөр дүүргэж төгссөн хүний их эмч мэргэжилтэй эмч нараар заалгах/
- Багшийн ажлын гүйцэтгэлээр үр дүнг үнэлж, цалингийн шатлал зэрэглэл, багшийн албан тушаалын зэрэглэлд нь өөрчлөлт оруулдог болох

- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг эрх зүйн зохицуулалт хийх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдалд хийсэн судалгаа, багш тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан, багш нарын багш хөгжлийн хөтөлбөр, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, багш нарын журнал, багшлахуйн ур чадвар ба судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг нь тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, багш нарын сургалтад хамрагдсан тайлан мэдээ, гадаад дотоодод мэргэжил дээшлүүлсэн багш нарын талаархи судалгаа

Онцлог зүйл:

- Багшлахуйн ур чадварыг сайжруулах ажлын хүрээнд тодорхой ажлуудыг хийж байгаа
- Багш нарын хийж бүтээсэн шинэ ажлуудыг хөхүүлэн дэмжих талаарх тодорхой заалтуудыг өөрийн сургуулийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох дүрэм журамд тусгаж, тэдний ажлын орчин нөхцөлийг сайжруулах, цалин орлогыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажилладаг байна
- Багш нарын судалгааны ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд багш нараа гадаадын гэрээт, хамтын ажиллагааны байгууллагуудад туршлага судлуулах, эрдмийн цол зэргээ ахиулах чиглэлд тусламж дэмжлэг үзүүлэн ажилладаг

Анхаарах асуудал:

- Багш нарын суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа байхгүй байгааг анхаарах
- Залуу багш нарыг дэмжих чиглэлд хийгдэж буй ажил тодорхой харагдахгүй байна
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд тусгагдсаны дагуу багшлах боловсон хүчний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлд дорвитой ажил хийгдээгүйг анхаарах

- Багшийн залгамж халааг тасралтгүй бэлтгэх чиг үүргийн хүрээнд сургуулийн мастер төлөвлөгөөнд тусгагдаж хийгдсэн ажил харагдахгүй байгааг анхаарах
- Багш нарын мэргэжил, багшлах ур чадвараа дээшлүүлсэн байдлаас харахад /хүснэгт 76/ сүүлийн 5 жилийн байдлаар 3 багш нарийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан нь анхаарал татаж байна

Зөвлөмж:

- Багш нарынхаа тасралтгүй боловсорч хөгжих сургалтын хэрэгцээг тодорхойлж үнэлэн, багш нарыг сургалтад хамруулах, залуу багш нарыг дэмжих, хөгжүүлэх чиглэлд ажлууд хийх
- Багш хөгжлийн төв байгуулж, үйл ажиллагааны чиг үүргийг гарган, үйл ажиллагааг нь тогтоомолжуулах, багш хөгжлийн хөтөлбөртэй болох
- Багш нараа үндэсний хэмжээний ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд идэвхтэй оролцуулж, ур чадварыг нь байнга хөгжүүлэх чиглэлд багшийн хөгжлийг дэмжиж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Эрдэм шинжилгээний фонд бүрдүүлэлт, эрдэм шинжилгээний бүтээлийн фонд бүрдүүлэлт, боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт судалгаа, инновац, оюуны өмчийн гэрчилгээ, ашигтай загвар ба патентын тоон судалгаа, сургуулийн дэргэд үйл ажиллагаа явуулдаг туршилт судалгааны лабораториудын үйл ажиллагаа, холбогдох зөвшөөрөл, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, холбогдох эрх зүйн баримт бичгүүд, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны тайлан, хөтөлбөрт тусгагдсан байдал, зарцуулсан төсөв тайлан, нийтлэгдсэн бүтээлийн тоо, судалгааны ажлууд, эшлэгдсэн тоо

Онцлог зүйл:

- НСМ-сургалтын шинэлэг санаагаа баталгаажуулж Оюуны өмчийн патент авч, ректорын 2020.06.22-ны өдрийн А/18 тоот тушаалаар Соёмбо хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь давуу тал болж байна

- Багш нар судалгааны ажилд гаршиж, шинэ арга зүй нэвтрүүлэх чиглэлд сургуулийн зүгээс 27 төсөв ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан нь нэн сайшаалтай байна
- Тус сургууль нь дэргэдээ Эрдэм шинжилгээ-Инновацийн төвийг байгуулж, үйл ажиллагаагаа тогтвортойгоор явуулж байгаа нь бахархалтай байна
- Багш нарын судалгаа шинжилгээний ажил хийх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байгаа нь харагдаж байна
- Профессор М.Амбагын бүтээлээс 180 ишлэл авагдсан байна

Анхаарах асуудал:

- Профессор М.Амбагын бүтээлийн эзлэх хувь их, хөтөлбөр хэрэгжүүлэгч бусад багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эзлэх хувь нэн бага байгааг анхаарах
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын үр дүнг хөтөлбөрийн хөгжүүлэлтэд хэрхэн тусгаж ажилладаг нь дурдагдаагүй байна
- Дэлхийн нэр хүнд бүхий IF өндөр сэтгүүлүүдэд хэвлүүлсэн багш нарын бүтээлийн эзлэх хувь бага байгааг анхаарах
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв хөрөнгө, тайланг дэлгэрэнгүй байдлаар /сүүлийн 5 жилээр/ задалж бичээгүйг анхаарах

Зөвлөмж:

- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд багш, судлаачдын бүтээлийг хэвлүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Багшийн өөрийн үнэлгээний тайлан, хөндлөнгийн үнэлгээний дүн, багшийн ажлын хавтас, багш хөгжлийн хөтөлбөрт хийсэн үнэлгээ, багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх ба дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан, багшийн өөрийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, зохион байгуулсан арга хэмжээний тайлан

Онцлог зүйл:

- Багш бүр ажлын төлөвлөгөө, үр дүнгийн тайлангаа бичиж, нэг сар тутамд ур чадварын ахиц гаргасан өөрийн үнэлгээний тайлан бичдэг
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бүр гурвалсан хичээлийн хөтөлбөрийн дагууд өөрийгөө хөгжүүлэх чиглэлд ажиллаж, хөндлөнгийн үнэлгээ хийлгэн, ажлаа төлөвлөж гүйцэтгэдэг

Анхаарах асуудал:

- Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг ямар журмаар дүгнэж үр дүнгийн үнэлгээ хийдгээ тодорхой болгох
- Сургуулийн мастер төлөвлөгөөний дагуу хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, багш нар ажлын төлөвлөлт хийж, үр дүнгээ тайлагнаж байх
- Багшийн ажлын хавтаст /хүснэгт 79/ багшийн өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө байна гэж заагдсан ч, багш нар хичээлийн шинэ жил бүр Багш хөгжлийн төлөвлөгөө гарган батлуулж, түүнийхээ дагуу өөрийгөө хөгжүүлэх чиглэлд хийгдсэн ажил байхгүй байгааг анхаарах
- БСШУС-ын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаалын Нийтлэг шаардлага батлах тухай, БСШУС-ын 2020.05.29-ний өдрийн А/270 тоот тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлагыг мөрдөн ажиллаж байгаа талаар тодорхой тусгаж ажиллах
- Дээд боловсролын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан “Аттестатчиллын журам”-ыг баримталж багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн чиглэлээр хийж гүйцэтгэх ажлыг нь үнэлж, багш тухайн албан тушаалын зэрэглэлд тавигдах нийтлэг шаардлагыг хэрхэн хангаж ажилласан, багшийн албан тушаалын зэрэглэл, ажлын үнэлэмжийг ахиулах, бууруулах чиглэлд хийгдсэн ажил харагдахгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Багшийн үйл ажиллагаанд 360 хэмийн үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнг багшийг чадавхжуулах, хөгжүүлэх богино, дунд, урт хугацааны мастер төлөвлөгөө, багш хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаж оруулах
- Багш нарын аттестатчилалыг явуулж, багшийн албан тушаалын зэрэглэлд өөрчлөлт оруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

Шинэ АУИС нь 2007 онд Дотоод хяналт-шинжилгээний алба нэртэйгээр орон тооны 2 ажилтантай байгуулан ажиллаж эхэлсэн бөгөөд 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/15 тоот ректорын тушаалаар Дотоод чанарын баталгаажуулалтын албаны бүтэц, дүрэм, жумыг шинэчлэн батлаж хөтөлбөрийн дотоод чанар баталгаажуулалтын албыг анх байгуулжээ.

Улмаар 2020 оны 10 сард Шинэ АУИС-ийн удирдах зөвлөлийн хурлаар сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн зохион байгуулсантай холбоотойгоор ректорын 2021 оны 02 сарын 22-ны А/07 тоот тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын баг байгуулан мөн өдрийн А/08 тоот тушаалаар албаны ажиллах журам, хяналт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг батлан 5 хүний бүрэлдэхүүтэй байгуулжээ.

Энэхүү алба нь гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөгөө сургалтын хөтөлбөр, багшийн үйл ажиллагаа, суралцагчийн үйл ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр эрхэлхээр төлөвлөн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хянан үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг өргөжүүлэн, эрчимжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерын өсөлт, ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацааны судалгаа хийж үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлэн ажиллаж байна

Анхаарах асуудал:

- Суралцагчдын гадаад хэлний мэдлэг, түүн дотор мэргэжлийн англи хэл хэрэглэх ур чадварыг дээшлүүлэх чиглэлийг хөтөлбөрт тусгах.
- Үйлдвэрлэлийн дадлагыг өргөжүүлэн зохион байгуулах

Зөвлөмж:

- Дадлагын болон ур чадвар эзэмшүүлэх хичээлийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх. Виртуал, цахим хичээлийн хэрэглээг нэмэгдүүлэх.
- Хөтөлбөрийн хороонд төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах
- Аливаа асуумж судалгааг цахим хэлбэрт шилжүүлж, тогтмолжуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

Хөтөлбөрөө үндэсний хэмжээнд 2022 онд, ОУ-ын түвшинд 2030 онд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэх зорилго, төлөвлөгөө гарган, стратеги төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна

Онцлог зүйл:

- Хөтөлбөрт оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтсон хугацаанд төлөвлөн зохион байгуулахаар ажиллаж байгаа

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл		+		<p>Сургалтад шаардлагатай эмнэлзүйн сургалт, судалгаа, ур чадварын төв болон лабораторийг зохих шаардлагад нийцүүлэн байгуулах.</p> <p>Лабораторит аюулгүй ажиллагааны заавар, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны заавар байршуулах, техник ашиглалтын бүртгэл хөтлөх</p> <p>Wi-Fi интернетийн үйлчилгээг тасалдалгүй хүргэх</p> <p>Оюутнуудын номын сангаар үйлчлүүлэх цагийн хуваарийг уртасгасан цагийн хуваарьт шилжүүлж, хүртээмжийг дээшлүүлэх</p>
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	+			
ДҮГНЭЛТ		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрт тусгагдсан кредитын тоог зохистой болгох - Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрт хичээл тус бүрээр хүрэх үр дүн үүнд зохих сурган заах арга зүй, үнэлгээний аргуудыг оруулах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Сонгон суралцах, бие даан сургалцах боломжийг сайжруулах, насанд хүрэгсдийн сурган заах арга зүйг нэвтрүүлэх - Оюутны үнэлгээний аргуудыг орчин үеийн боловсрол судлалыг чиг хандлагын дагуу илүү боловсронгуй болгох
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Лабораторийн орчныг сайжруулан стандартын дагуу зохион байгуулах, тоог нэмэгдүүлэх, оюутны хичээл хийх нөхцөлийг сайжруулах. - Мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага бичихэд мэргэжлийн холбоотой хамтран ажиллах - Мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг зохиогчийн эрхийн дагуу цахим санг баяжуулах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн тасралтгүй хөгжүүлэлт хийж, хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах - Гадаад, дотоодын хамтын ажиллагааны гэрээнүүдийг шинэчлэх - Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тогтмолжуулах - Хөтөлбөрийн маркетинг хөгжүүлэлтэд багш нарын идэвх оролцоог нэмэгдүүлэх - Сургуулийн вебсайтад хөтөлбөрийн талаархи дэлгэрэнгүй танилцуулга оруулах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Суралцагчид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хэсгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих - Сургалтын үйлчилгээний чанарт үнэлгээ хийн, тасралтгүй сайжруулалт хийх - Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалж ажиллах - Хөдөлмөр эрхлэгч оюутнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг зохих дүрэм журмын дагуу мөрдөж ажиллах, багшийн үйл ажиллагааны үнэлгээг боловсронгуй болгож - Хөтөлбөрийн зорилгод нийцсэн хүний нөөцийн цогц бодлоготой болох - Багш хөгжлийн төв байгуулж багш хөгжлийн хөтөлбөртэй болох, багш нарынхаа тасралтгүй боловсорч хөгжих сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтыг зохион байгуулах - Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд багш, судлаачдын бүтээлийг хэвлүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллах
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг өргөжүүлэн, эрчимжүүлэх

	<ul style="list-style-type: none"> - Дадлагын болон ур чадвар эзэмшүүлэх хичээлийн материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх. Виртуал, цахим хичээлийн хэрэглээг нэмэгдүүлэх. - Хөтөлбөрийн хороонд төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах - Аливаа асуумж судалгааг цахим хэлбэрт шилжүүлж, тогтмолжуулах - Хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх
Шалгуур	Шаардлага
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Сургалтад шаардлагатай эмнэлзүйн сургалт, судагаа, ур чадварын төв болон лабораторийг зохих шаардлагад нийцүүлэн байгуулах. - Лабораторийн аюулгүй ажиллагааны заавар байршуулах. - Техник ашиглалтын бүртгэл тогтмол хөтөлж хэвших. - Тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны заавар байршуулах - Номын санд Wi-Fi интернетийн орчныг тасалдалгүй ажиллагаагаар хангах - Номын сангийн ажиллах цагийн хуваарийг уртасгасан цагийн хуваарьт шилжүүлж, хүртээмжийг дээшлүүлэх

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинэ Анагаах Ухаан их сургуулийн “Анагаах ухаан” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

Б.Лагшмаа
П.Пунсалдулам
Л.Мөнхтулга

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

Д/д	Овог	Нэр	Албан тушаал	Зэрэг, цол	Мэргэжил	Ажилл асан жил	Заадаг хичээл
1	Гантулга	Орхонтуяа	Багш	Докторант	Эмч	7	АУ-ы удам зүй
2	Батлхагва	Сугармаа	Тэнхимийн эрхлэгч, онолын асуудлууд, эрүүл физиологи 1 хичээлийн багш	Докторант	Эмч	8	Эрүүл физиологи
3	Лхамдорж	Дагвасамбуу	Тэнхимийн эрхлэгч, багш	Магистр	Технологи ч	9	Биохими
4	Баатар	Мөнх-Эрдэнэ	Багш	Докторант	Химич	10	Анагаахын хими
5	Готовдорж	Түвшинжаргал	Тэнхимийн эрхлэгч	АУ-ы доктор	Молекул биологич	20	Молекул биологи
6	Цэрэнпунц аг	Энхбат	Тэнхимийн эрхлэгч, багш	АУ-ы магистр	Эмч	16	Дотоод шүүрлийн булчирхайн ЭС
7	Ганболд	Мягмарбаатар	Багш	Докторант	Эмч	13	Уушгины ӨС
8	Цэнгэл	Насантогтох	Багш	Докторант	Эмч	8	NCM-АУ

№	Овог нэр	Оюутны код	Анги
1.	Нэргүй Тэмүүжин	AU2017D013	АУ-6
2.	Сүх-Очир Даваажаргал	AU2017D058	АУ-6
3.	Оюунцэцэг Сийлэгмаа	AU2017D066	АУ-6
4.	Занданхүү Балжинням	AU2017D033	АУ-6
5.	Гүрбазар Цэвээнсүрэн	AU2018D035	АУ-5
6.	Дамдиндорж Энхтуул	AU2018D037	АУ-5
7.	Бат-Эрдэнэ Ууганбаяр	AU2018D071	АУ-5
8.	Мөнх-Эрдэнэ Мөнхнаран	AU2018D028	АУ-5
9.	Бат-Эрдэнэ Тэнгис	AU2019D013	АУ-4
10.	Лхагвасүрэн Чойжамц	AU2018D090	АУ-4
11.	Амарбаясгалан Сарантуяа	AU2019D026	АУ-4
12.	Төмөрсүх Нандин-Эрдэнэ	AU2019D025	АУ-4
13.	Энхбат Бум-Эрдэнэ	AU2020D018	АУ-3
14.	Нямдэлэг Номин	AU2020D029	АУ-3
15.	Цогтсайхан Бямбацэрэн	AU2020D040	АУ-3
16.	Отгонгэрэл Доржпүрэв	AU2020D033	АУ-3
17.	Батцэнгэл Цэрэнхүү	AU2021D009	АУ-2
18.	Батсуурь Нямдаш	AU2021D024	АУ-2
19.	Саруул Тэргэл	AU2021D041	АУ-2
20.	Бямбадорж Батцэцэг	AU2021D070	АУ-2
21.	Дүүрэнбаяр Анунгоо	AU2021D122	АУ-2
22.	Намжилдорж Намуунаа	AU2022D009	АУ-1
23.	Батзориг Галбадрах	AU2022D034	АУ-1
24.	Эрдэнэбулган Баасандорж	AU2022D013	АУ-1

II. Оюутнуудтай хийх уулзалт

IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

Ариунболд	Алтанзул	эмэгтэй	Au2016d113@ncm.edu.mn	99608653
Батсайхан	Ариунням	эмэгтэй	au2016D082@ncm.edu.mn	88544228
Энэбиш	Байгалмаа	эмэгтэй	E.Baigalmaa.90@gmail.com	90710244
Нармандах	Баяржаргал	эмэгтэй	au2016d064@ncm.edu.mn	88820264
Ариунболд	Бэрхболд	эрэгтэй	aberhbold@gmail.com	99556752
Барьдинцоо	Ганзаяа	эмэгтэй	ganzaya.zaya22@gmail.com	99152055
Түвдэндорж	Гэрлээ	эмэгтэй	gerleetudevдорж@gmail.com	90848881
Цогтбаатар	Дашдолгор	эмэгтэй	Maashkaa.8918@gmail.com	89189638
Мөнхзул	Долгормаа	эмэгтэй	dolgormaamunkhzul@gmail.com	95334271
Эрдэнэ-Очир	Мөнхнасан	эмэгтэй	emunkhnasan01@gmail.com	95224260

эрдэнэбаяр	мягмарнаран	эмэгтэй	AU2016d039@gmail.com	89904797
Нямхүү	Мягмарсүрэн	эмэгтэй	Au2016D068@ncm.edu.mn	91302646
Цогтбаатар	насанжаргал	эмэгтэй	nasaan751@gmail.com	88660426
Энх-од	Номиндарь	эмэгтэй	nomindari09@gmail.com	91116419
Батсүх	Оюунбаяр	эмэгтэй	oyuka139@gmail.com	88853525
Болдэрдэнэ	Өлзийсайхан	эмэгтэй	ulziisaikhan1998@gmail.com	89855880
Бадрах	Сандагсүрэн	эрэгтэй	Sandagsuren88@gmail.com	88106908
Эхбаяр	Саруул	эмэгтэй	Esakana@yahoo.com	93333005
Мандалбаяр	Төмөрчөдөр	эрэгтэй	chudurchudur79@gmail.com	91433100
Уламбаярын	Цэрэнбалжир	эмэгтэй	TseegiiUka0527@gmail.com	95100998
Болдбаатар	Дэлгэрдалай	эрэгтэй	Au2016d022@ncm.edu.mn	8082 0260

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/


 ИХ СУРГУУЛЬ
 "ШИНЭ АНАГААХ УХААН"
 ИХ СУРГУУЛЬ
 ШИНЖЛЭХ УХААН - СЭРГАЛТ - ЭМЧИЛГЭЭ
 - ҮЙДВЭРЭЭЛИЙН ЦОГЦОЛБОР
 Улаанбаатар хот, Zip code-18130
 Сонгинохайрхан дүүрэг-20
 Сонголон /18130/Товчооны зам 5/2
 Утас: 70183235 Факс: 976-70183235
 E-mail: info@ncm.edu.mn
 Website: www.ncm.edu.mn
 2022.10.15 № 210

талай _____ № _____

Хүсэлт хүргүүлэх тухай

"Шинэ Анагаах Ухаан" Их Сургуулийн /Анагаах ухаан-D091201/ хөтөлбөрт шинжээчдийн багийн өгсөн нэгдсэн зөвлөмж, шаардлагыг хүлээн авч цаашид хөтөлбөртөө тусган ажиллана.

РЕКТОР, ПРОФЕССОР



М.АМБАГА

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД